



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 32-31-58, 26-06-13
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2017.05.03 № 10/3499
тагай _____-ны № _____-т

**Тодотгосон төсөв хүргүүлэх,
төсвийн хэрэгжилтийг хангуулах тухай**

Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдлаа.

Мөн “Монгол Улсын Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 29-р тогтоол батлагдлаа.

Тус тогтоолоор холбогдуулан төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр салбартай холбоотой дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасан байна. Үүнд:

- төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх;
- төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах;
- эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдлын салбараас 2017-2019 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 төрийн албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилох, энэ хугацаанд бусад салбарт төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байж, ажил, үүргийн хуваарийг шинэчлэн оновчтой тогтоох замаар ачааллыг нягтруулах, сул орон тоог зайлшгүй нөхөх шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад дахин зохион байгуулалт хийх зарчмаар шийдвэрлэх зэрэг болно.

Иймд салбарын 2017 оны төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Та дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д зааснаар Төсвийн шууд захирагч нь “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр

дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” бүрэн эрхээ хэрэгжүүлэх;

- Батлагдсан тогтоолын “бусад салбарт төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлэхдээ байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоож байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх;

- Тогтоолын дагуу 2017-2019 онд салбарын харьяа бүх байгууллагын төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг түр зогсоох;

- Төсвийн гүйцэтгэлийг хангуулахдаа Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2-т заасны дагуу “батлагдсан төсвийн хүрээнд төсвийг зарлага гаргах”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь заалтад заасан “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” зарчмыг хатуу барьж ажиллах шаардлагатай байна. Хэрвээ албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан өр, авлага үүссэн бол тухайн албан хаагчид хуулийн дагуу хариуцлага тооцдог байх зэрэг болно.

Тодотгосон төсвийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

 Ж.БАТСУУРЬ